

БИЧГИЙН ШАЛГАЛТЫН ҮЕЭР СУРАГЧДЫН БАРИМТЛАХ ДЭГ

1. Шалгалтын материал 6 дугаар ангийнх нийт 50 асуултаас бүрдэх ба асуулт тус бүр 2 оноотой, 7 дугаар ангийн шалгалтын материал нийт 60 асуултаас бүрдэх ба математик, монгол хэлний асуулт тус бүр 2, англи хэлний асуулт тус бүр 1 оноотой. Үүнд:

6 дугаар анги

Математик-30 асуулт

Монгол хэл-20 асуулт

7 дугаар анги

Математик-30 асуулт

Англи хэл-20 асуулт

Монгол хэл-10 асуулт

- ✓ Шалгалтын нийт хугацаа 120 минут байна.
- ✓ Хувилбараа тэмдэглэхээ бүү мартаарай.
- ✓ Хариултын цаасан дээр эрээчиж болохгүй.
- ✓ Хариултаа заавал балаар тэмдэглэнэ.
- ✓ Хариултаа дарсан, тэмдэг тавьсан, зурж балласан, засвар оруулсан тохиолдолд тухайн хариултыг хүчингүйд тооцно.
- ✓ Шалгалт эхлэхээс өмнө хариултын хуудсанд өгөгдсөн сурагчийн мэдээллийг заавал бөглөнө. (овог, нэр, анги, сургууль, хувилбар гэх мэт)
- ✓ Шалгалт эхэлснээс хойш хамгийн эртдээ 60 минутын дараа ангиас гарч болно.
- ✓ Шалгалт эхлэхэд шалгалтын материалыг сайтар шалгана уу.
- ✓ Шаардлагатай тайлбар ба нэмэлт мэдээллүүд шалгалтын материалд өгөгдсөн тул шалгалт эхэлснээс хойш хянагч багшаас асуулт асуухыг хориглоно.
- ✓ Сурагчид хоорондоо ярилцах, бие биетэйгээ харандаа, баллуур зэргийг солилцохыг хориглоно.
- ✓ Асуулт тус бүрт нэг зөв хариултыг бөглөнө.
- ✓ Нэмэлт цаас өгөгдөхгүй, бодолтыг шалгалтын материал дээрх хоосон зайд хийж гүйцэтгэнэ.
- ✓ Сурагчдыг тооны машин, гар утас, толь бичиг зэргийг ашиглахыг хориглоно.
- ✓ Шалгалт эхэлснээс хойш ангиас ямар нэгэн шалтгаан/ариун цэврийн өрөө орох гм/-аар гарахыг хориглоно. Ангиас гарсан сурагчийг ангид дахин оруулахгүй.
- ✓ Бусдаас хуулсан болон бусдад хуулуулсан сурагчдын шалгалтын материалыг хүчингүйд тооцно.
- ✓ Шалгалтын дараа шалгалтын материал, хариултын хуудас, бүртгэлийн хуудсыг хурааж авна. Эдгээр материалуудыг хянагч багшид хүлээлгэж өгөөгүй сурагчийн шалгалтын материалыг хүчингүйд тооцно.
- ✓ Бичгийн шалгалтад тэнцсэн сурагчид шалгалтын дараагийн шат буюу ярилцлагад орох эрхтэй болно.